

**ДУНДГОВЬ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дүгээр сарын 10

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая,төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
					Он	Түвшин			
2.5 Үндэсний бахархал, өв соёл									
1	Аймгийн ДНТ-д соёл, урлагийн салбарын эзлэх хувь 2019 онд 0.61 хувьд байсныг 2025 онд 0.81 хувьд хүргэнэ.	2021-2025		ДНТ-д эзлэх өсөлтийн хувь	2020	0.61	0.73	-	-
1.1	Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх, арга хэмжээнд хамрагдсан иргэд 2019 онд 294454 байсныг 2025 онд 46400-аар нэмэгдүүлнэ.	2021-2025	УТХО, ОНТ 1344.1	Соёл, урлагийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	2020	294454	322294	Соёл, урлагийн байгууллагууд монгол өв соёл, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, урлаг уран бүтээлийн чиглэлээр нийт 2912 арга хэмжээ, сургалт сурталчилгааг зохион байгуулж, давхардсан тоогоор 361551 иргэн хамрагдлаа.	100
1.1.1	2020 онд соёл, урлагийн салбарт насжилт өндөртэй барилга байгууламж 14 байгааг 2025 онд 85.7 хувийг шинэчилж чанартай тоног төхөөрөмжөөр хангана.	2021-2025	УТ 313.5	Шинээр баригдсан барилгын тоо	2020	0	2	Цагаандэлгэр сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч Хэрмээдэй ХХК нь төсөвт өртөг 1,523.4 сая төгрөг, тайлант хугацаанд гүйцэтгэлээр 709,669.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон. 1, 2 давхрын дотор өрлөгийн ажил хийгдэж дууссан. Дотор засал, шаврын ажил эхлэх гэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 75 хувийн гүйцэтгэлтэй байна.	82.5

								Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгч ОДДА ХХК нь төсөвт өртөг 1,429.25 сая төгрөг, тайлант хугацаанд 780.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Барилгын өрлөгийн ажил дууссан. Гадна тохижилт, дотор заслын ажил хийгдэж, гүйцэтгэл 90 хувьтай байна. Барилгуудын гүйцэтгэлийн дундаж 82.5 хувьтай.	
1.1.1.1	Төв халхын дуулалт жүжгийн театр шинэ барилга барьж ашиглалтад оруулна.	2021-2025	ОНТ 70.0	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2020	10	100	Соёлын яамнаас 2 удаа цахим хэлэлцүүлэг зохион байгуулагдсан. Хэлэлцүүлгээр барилгын ажлыг хуучин суурь дээр үргэлжлүүлэн барих, зураг төсвийг дахин шинэчлэн гаргахад шаардагдах хөрөнгө 250.0 сая төгрөгийн 70.0 сая төгрөгийг аймаг орон нутаг шийдвэрлэлээ.	28
1.1.1.,	Хүүхдийн театрын шинэ барилга барьж ашиглалтад оруулна.	2021-2025	4500.0 УТХО	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2020	0	70	Аймгийн Засаг даргын 2022 оны А-188 тоот захирамжаар олгосон газар олголт, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын 2023 оны 11 тоот албан бичгийн дагуу "БЕС онцгой дизайн" ХХК театрын барилгын суурь холболтын зураг төсөлийг хийж гүйцэтгэсэн.	-
1.1.2	Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 60 байгааг 2025 онд 78.8 хувьд хүргэнэ.	2021-2025	УТ 16.7 ОНТ 18.5	Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны эзлэх хувь	2020	60	68.3	Соёл, урлагийн салбарын мэргэжилтэй ажилтны батлагдсан орон тоо 138 үүнээс 2023 жилийн эцсийн байдлаар 72.5 хувь буюу 100 ажилтантай.	100
1.1.2.1	Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, орон тоог			Шинээр нэмэгдүүлсэн бүтэц орон тоо	2020	0	10	-	-

нэмэгдүүлэн салбарын ажилтнуудыг гадаад дотоодын их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлнэ.	2021-2025	УТ 16.7 ОНТ 18.5	Тухайн жилд шинээр бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчний тоо		4	12	Уртын дууны чиглэлээр 2, дүрслэх урлаг-1, соёлын өв - 14, хөгжим- 2, бүжиг 1, дууны техникчээр 19 ажилтан, ТХДЖТ мэргэжлийн 2 дуучин, 1 бүжигчин, 1 хөгжимчин, нийт 43 ажилтны мэргэжлийг дээшлүүлж мэргэжилтэй ажилтаны тоог нэмэгдүүллээ.	100
			Гадаад дотоодын сургалтад хамрагдсан ажилтны тоо /давхардсан тоогоор/		205	300	Мэргэжлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх чиглэл өгснөөр СУИС-ийн харьяа Бадмаараг сургуулийн бүжгийн ангид 1, Сити дээд сургуулийн бүжгийн ангид 1, МУК-ын Бүжиг циркийн сургуулийн ардын бүжгийн ангид 5, Соёл урлагийн дээд сургуульд нэг өвийн ажилтан, Соёл урлагийн их сургуульд нэг хөгжмийн багш нийт 9 албан хаагч суралцаж байна. Мэргэжлийн их дээд сургуульд нийт 9 хүн суралцахаар элсэн орж, 7 суралцагчид "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн зардлаас 722,0000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийт мэргэжилтэй ажилтны тоог 4-өөр нэмэгдүүлсэн. Мэргэжлийн чиглэлээр гадаадад 2 удаагийн сургалтад 19 соёлын ажилтан, улс болон аймаг орон нутгаас зохион байгуулагдсан цахим болон танхимын 75 төрлийн сургалтад 19, байгууллагын давхардсан тоогоор 525 албан хаагч хамруулж, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлэн чадавжуулснаар ажлын бүтээмж дээшилж, олон улс, улсын хэмжээний арга	100

								хэмжээг чанартай сайн зохион байгуулсан.	
1.1.2.2	Соёл, урлагийн салбарын ажилтнуудыг орон сууцжуулна.	2021-2025	ОНТ 12.5	Орон сууцанд орох хүсэлт гаргасан ажилтнуудын шийдвэрлэлтийн хувь	2019	0	6	Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн судалгаагаар нийт 175 ажилтан албан хаагчид ажиллаж байгаагийн 62 буюу 34 хувь орон сууцанд, түрээсийн байранд 16 буюу 8,8 хувь хашаа байшин, гэрт 104 буюу 57,1 хувь амьдарч байна. Байр, орон сууцанд орох 6 албан хаагчийн хүсэлт ирсний дагуу 4 сум 6 албан хаагчийг байгууллагын орон сууцанд оруулж, аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд нэг уран бүтээлчид байр орон сууцанд ороход 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Албан хаагчийг 100 хувь шийдвэрлэн орон сууцанд оруулснаар амьдрах таатай орчин бүрдэж, ажлын бүтээмжийг нэмэгдүүллээ.	100
1.1.3	Монгол зан заншил өв соёлоо дээдэлсэн эв нэгдэл, эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээнд хамрагдагчдыг 2020 онд 986 байгааг 2025 онд 6500-д хүргэнэ.	2021-2025	ОНТ 1.4	Арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	2020	986	4500	"Эх түүхийг эрэгцүүлэхүй" хүндэтгэлийн түүхэн тоглолт, "Монгол бахархал-Өв соёл" едөрлөг, "Нандин шүтээн" тусгай үзэсгэлэн, Уламжлалт шагай хамах, "Танграм" тоглоом ЕБС-ын сурагчдын дунд, Аймгийн монгол бичгийн "Тэргүүний хурдан уншигч" шалгаруулах уралдааныг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд нийт 4178 иргэд, хүүхэд багачууд хамрагдлаа.	92.8

1.1.3.2	"Бүрдийн уянга" хүүхдийн зусланг түшиглэн "Ардын зан үйл амьдрах арга ухаан" хөтөлбөрт сургалтыг зохион байгуулна.	2021-2025	УТ 43.9	Тухайн жилд зохион байгуулсан сургалтын тоо	2020	0	4	Аймгийн Засаг даргын тамгын газар, Соёл, урлагийн газар, Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, говийн бүсийн аймгуудтай хамтран Данзанравжаагийн 220 жилийн ойн хүрээнд "Говийн хүүхдүүд" урлагийн наадмыг зохион байгуулж, мөн 6 аймгийн хүүхдийн чуулганаар аймгийн Музейгээс "Ардын зан үйл амьдрах урлаг", "Монгол бичиг", тоглоом наадгай гэсэн 3 төрлөөр хөтөлбөрт сургалт, Төв номын сан "Дундговь аймгийн 9-н гайхамшиг", "Сүм хөх бүрд", "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театраас морин хуур, уртын дууны сургалт, "Номын есөн өртөө" нийт 9 төрлийн сургалтыг зохион байгууллаа. Нэрт соён гэгээрүүлэгч Ноён хутагт Данзанравжаагийн уран бүтээл, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх, хүүхэд багачуудад эх оронч үзэл, үндэсний өв соёлыг хайрлан хамгаалах ач холбогдлыг ойлгуулж, олон нийтэд сурталчлан таниулсан ажил боллоо.	100
				Тухайн жилд хөтөлбөрт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	0	0	400	Бүрдийн уянга зуслан дээр зохион байгуулагдсан бүс, аймгийн хэмжээний сургалт үйл ажиллагаанд давхардсан тоогоор 6 аймгийн 499 хүүхэд хамрагдсан.	-

1.1.3.3	Хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх, Ирээдүйн соёлтой үйлчлүүлэгч төслийг сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж Монгол өв соёл, ардын уламжлалт урлагаа сурталчлан таниулна.	2021-2025	ОНТ 2.0	Зохион байгуулсан сургалтын тоо	2020	15	19	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театр, соёлын төвүүдэд уртын дуу, ардын дуу, морин хуур, ятга, ёочин, лимбэ, шанз, бөмбөр цохивор, утсан хөгжим, даралтат хөгжим, бүжиг, сур харваа, "Оюунлаг тархи", гийнгоо, зээ татах, шатар, даам, морь, бөх цоллох, утас ээрэх, ширдэг ширэх, дээс томох, зоос ширээний нэхмэл, зүү ороох, товч хадах, эсгий урлал, оньсон тоглоом, шагайн 4 төрөл наадгай, нийт 28 төрлийн сургалт зохион байгуулж, өв соёлоо сурталчлан, зааж сурган, ардын урлалын 16 бүтээл гаргалаа.	93.3
				хамрагдсан хүүхдийн тоо	2020	986	4500	Зохион байгуулсан сургалтад 3899 хүүхэд хамрагдсан байна	
1.1.3.4	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын үйл ажиллагааг өргөжүүлэн Дуу хуурын өлгий нутгийн залгамж халааг бэлтгэнэ.	2021-2025	ОНТ 20.0	Зохион байгуулсан дугуйлангийн төрөл	2020	25	35	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын сургагч багш нар нийт 7 төрлийн 38 дугуйлан хичээллүүллээ.	83.5
				дугуйланд хамрагдсан хүүхдийн тоо	-	393	600	Урлагийн боловсрол олгох сургалтаар нийт 513 хүүхэд суралцлаа.	
			-	Дугуйланд хамрагдагдсаас соёл, урлагийн чиглэлээр элсэн суралцсан хүүхдийн эзлэх хувь	-	1.5	2.6	Мэргэжлийн сургуульд ур чадварын шалгалтгүйгээр элсэн орох эрхийн бичгийг 5 сурагчид эрхийн бичиг олгож СУИС-ийн харьяа Бадмаараг сургуулийн бүжгийн ангид 1, Сити дээд сургуулийн бүжгийн ангид 1, Монгол Улсын консерваторын Бүжиг циркийн сургуулийн ардын бүжгийн ангид 5 хүн, Соёл урлагийн дээд	

								сургуульд 1 өвийн ажилтан Соёл урлагийн их сургуульд 1 хөгжмийн багшаар элсэн орсон.. Нийт дугуйлангийн сурагчдын 1.7 хувь буюу 9 хүүхэд суралцаж байна.	
1.2	Нүүдэлчдийн өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлж бүх нийтийн урлагийн боловсролыг дээшлүүлэх, замаар дуу хуур брендийг өвлүүлэн хөгжүүлэх соёл, урлагийн арга хэмжээ 2019 онд 1431 байсныг 2025 онд 2876 д хүргэнэ.	2021-2025	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1431	2298	Салбарын байгууллагуудад хүүхдүүдийн үндэсний хэл, соёл, уламжлал, зан заншлаас суралцах, өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгснөөр аймгийн хэмжээнд 32 төрлийн дугуйланд 1644 хүүхдийг хамруулж сургалаа. "Ардын зан үйл амьдрах арга ухаан", "Монгол бахархал" хөтөлбөрүүд, "Говийн хүүхдүүд" Говийн бүсийн урлагийн наадам, "Хамтран бүтээцгээе" тоглоомын өртөө "Монгол бичиг" өртөө, арга хэмжээнд 4 аймгийн 220 хүүхэд, нийт 1830 иргэнийг хамрууллаа. Өв соёлын үзүүлэлэг хийх арга зүйн чиглэлийг сумдад 13, сургуульд 1, нийт 14 удаа арга зүйн дэмжлэг өгч, шилдэг 30 үзмэрийг зургаар нь таниулан AR төхөөрөмжөөр нүүдлийн үйлчилгээг давхардсан тоогоор нийт 570 иргэнд хүргэлээ.	100	
			-	Бүх нийтийн урлагийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	40	Музейн боловсролын хөтөлбөрийн хүрээнд Соёл, урлагийн газар, Музей, Номын сан, Прокурорын газар, Сайнцагаан сум ЗДТГ хамтран "Өв соёлын өртөө", "Шагай наадгай", "Өв соёл", "Тоглоом наадгай", "Хүүхдүүдтэйгээ хамтдаа" үйл ажиллагааг зохион байгуулж 55 гэр бүлийн 84 эцэг,	75	

								эх, хүүхдүүд хамрагдсан мөн Өндөршил сум "Өв соёлын өлгийн-Өндөршил" дэд хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллалаа.	
1.2.1	Монгол үндэсний өв соёлыг орон нутгийнхаа онцлогт нийцүүлэн туурвисан шинэ уран бүтээл 2020 онд 7 байсныг 2025 онд 2 дахин нэмэгдүүлнэ.	2021-2025	УТ 40.0	тухайн жилд туурвисан хүүхдэд зориулсан шинэ уран бүтээлийн тоо	2020	2	2	"Солгой харандаа", "Болдоггүй бор өвгөн", "Таягт" хүүхэлдэй жүжиг, "Жангарын 12 баатрын магтаал", "Миний хөөрхөн шүдний аялал" хүүхэлдэйн жүжиг, "Угалз" хамтлагийн өвөл цагийн нээлтийн тоглолт 5 удаа нийт 6 шинэ уран бүтээл найруулж, үзэгчийн хүртээл болгосноор нийт 3676 хүүхдийг соён гэгээрүүлж, чөлөөт цагийг нь зөв, үр ашигтай өнгөрүүллээ. Хүүхдийн уран бүтээлийн сан баяжигдаж, цаашид энэхүү уран бүтээлээрээ үйлчлэх, орлого олох нөхцөл бүрдсэн.	100
			ОНТ 125.7	туурвисан уран бүтээлийн тоо	2020	5	8	"Монгол түмнээ хүндлэн золгоё", "Эрхэмсэг", "Хоймор дүүрэн хийморь", "Эх түүхийг эргэцүүлэхүй", "Их хүндэтгэл", "Нар нь нүүдэллэсэн тэнгэрийн аялгуу, "Наран дуулал", "Их газрын чулуу", "Аниртай үдэш" 9 уран бүтээлийг шинээр болон шинэчилэн туурвиж, 370823 иргэнд соёлын үйлчилгээг хүргэснээр үйлчлүүлэгчдийн соёлын боловсрол дээшилж, үндэсний хэв шинжийг агуулсан урын сан баяжилт нэмэгдсэн	
			Төсөл хөтөлбөр 0.820						

1.2.1.2	Уяхан замбуу тивийн наран уртын дуучид морин хуурчдын эвент наадмыг зохион байгуулна.		УТ 160.0	Эвент наадмыг зохион байгуулсан эсэх Тийм-1, үгүй-0	2019	1	1	"Уяхан замбуу тивийн наран" уртын дууч, морин хуурчдын их наадмыг байгалийн задгай театрт зохион байгуулж, нутгийн 55-аас дээш насны ахмад 1176, хүүхэд 706, 19-54 насны авьяастан 1218 нийтдээ 3100 авьяастанг сургаж, хамрууллаа. Улсын хэмжээнд хамгийн олон үзэгчтэй наадмаар тодорхойлогдож, 47 мянган иргэнд нутгийн үнэт өв соёлыг түгээн сурталчилж чадлаа.	100		
			ОНТ 661.5				3000		3000	Шавь сургалтад морин хуурд-471, уртын дуунд- 2682 авьяастнууд бэлтгэгдэж, уртын дуу морин хуурын их наадамд амжилттай оролцлоо.	-
			-			наадмыг гиннест бүртгүүлсэн эсэх	0		1	-	-
1.2.1.4	Дуу хуурын өлгий нутгийн алдартан гавьяатнуудын хөдөлмөр бүтээлийг сурталчлан алдаршуулна.		УТ 192.9	Алдартан гавьяатнуудын нэрэмжит болгон зохион байгуулсан арга хэмжээний тоо		0	6	Аймгийн хэмжээнд "Уяхан замбуу тивийн наран" их наадам, Д.Данзанравжаагийн 220 жилийн ойн "Говийн бүсийн урлагийн их наадам", С.Буяннэмэхийн уран бүтээлийг сурталчлах, тэмдэгтэн шалгаруулах, Д.Дорждагвын нэрэмжит аймгийн хүүхдийн урлагийн наадам, МУГЖ Ж.Дунжмаагийн удирдсан дугуйлангийн "Уран бүтээлийн тоглолт", "Соёлын сэргэлт" аян, яруу найрагч П.Нямлхагвын	100		

								“Унаган туурай” тоглолт, улсын хэмжээний “Нүүдэлчин” Дэлхийн соёлын фестиваль, үндэсний их баяр наадмын үйл ажиллагаагаар нийт 9 арга хэмжээг зохион байгуулснаар нутгийн 38 СББӨ-ийн өвлөн уламжлагч, өв соёлыг олон нийтэд сурталчлан таниуллаа.	
1.2.1.5	Дуу хуурын өлгий Дундговь аймгийн түүхэн онцлог ёс заншил, зан үйл өв уламжлал болон түүх соёлын дурсгалуудыг баримтат болон уран сайхны кинонд буулган, нүүдэлчин монголчуудын өв соёлыг харуулсан баримтат өвийг бий болгоно.		-	Уран сайхны кино хийсэн эсэх 1-тийм 0-үгүй		0	1	-	-
1.1.3.1	Сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сумын гэрээт хамгаалагчтай болгох	2021-2025	-	Сумдын гэрээт хамгаалагчдын тоо	2020	0	30	Дундговь аймгийн 15 сумын улс аймаг, орон нутгийн хамгаалалттай 408 дурсгалт газрыг 197 малчинтай сайн дурын гэрээ байгуулсан. Гэрээг хагас, бүтэн жилээр 2 удаа дүгнэн, гэрээгээ сайн биелүүлж ажилласан иргэнд жилийн турш урлаг, соёлын арга хэмжээнд үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрх олгож урамшуулсан. Үүний үр дүнд сумдын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалт хамгаалалтад ямар нэгэн зөрчил гаргаагүй.	100

1.2.1.3	Музейн сан хөмрөгийг насжилт өндөртэй эртний үзмэрүүдээр баяжуулах	2021-2025	-	Баяжуулсан үзмэрийн тоо	2020	5	29	1910 оны Дээд язгууртан эмэгтэйн гоо сайхны сав, алдартны хувцас, хэрэглэл, бичгийн хэрэглэл, хэрэглэж байсан эд зүйлс, Одоо хийгдэж байгаа гар урлалын зүйлсийг цуглуулга /эсгий, ноос, арьс, шир, модон урлал/, 1921-1980-аад оны үеийн айл гэрийн тавилга, Оёдол үйлийн багаж хэрэгсэл, оёдлын машин, зүү, утас, илүүр, индүү, үйлийн хайч, зах зээлийн дараа Монголд нэвтэрсэн, өргөн хэрэглээ болж байсан гадаад, дотоод орны хувцас, гутал ахуйн хэрэглээний эд зүйлс, Хөсөг, тээвэр, машин техник хэрэгсэл, Монголын аж ахуйн холбогдолтой эд зүйл зэрэг музей сан хөмрөгтөө 31 дэсийн 41 үзмэрийг хандив цуглуулгаар авч баяжууллаа.	100
1.2.1.6	Аймгийн гар урчуудын бүтээлээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж дэг сургууль, арга барилыг өвлүүлнэ	2021-2025	-	Үзэсгэлэн худалдаанд оруулсан гар урчуудын тоо	2020	30	75	"Соёлын сэргэлт-2023" аян, "Нүүдэлчин-2023" Дэлхийн соёлын фестиваль, "Уяхан замбуу тивийн наран" их наадам, "Дундговь түншлэл-2023" арга хэмжээнд давхардсан тоогоор 489 соёлын бүтээлч үйлдвэрлэгч 1958 бүтээлээр үзэсгэлэн худалдаа оролцлоо.	100
			-	Шавь сургалтын тоо		0	45	Соёлын биет бус өвийн 8 өвлөн уламжлагч модон эдлэл, суран эдлэл, арьс элдэх, эсгий эдлэл, зүү ороох урлаг, гэсэн 5 төрлөөр шавь 9 удаагийн сургалтад 50	

						иргэнийг хамрууллаа. Мөн Өвлөн уламжлагч А.Ичинхоролыг Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөлд хамруулж, хүүхдүүдийн дунд "Арьс элдэх, энчлэх" 1 сарын сургалтыг зохион байгууллаа.	
	Нийт дүн						95.9

ХЯНАСАН:
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Х.ЦОГЗОЛМАА

Б.НАДМИДЦЭРЭН